

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БУЛГАН СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитын код: ДОА-2022/04/НА/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2022 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	8
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	9
3.8 Аудитын гол асуудал	9
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	9
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	10
4. Аудитын илрүүлэлт	10
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	11

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аудитын газар
НА	Нотлох аудит
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СХС	Сум хөгжүүлэх сан
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	650,840,0	893,326,6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	186,532,8	432,101,4
33	АВЛАГА	221,821,5	189,690,9
35	БАРАА МАТЕРИАЛ	242,485,7	271,534,4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,855,377,1	3,803,139,0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,855,377,1	3,803,139,0
39200	Биет хөрөнгө	3,786,449,8	3,736,425,3
39300	Биет бус хөрөнгө	68,927,2	66,713,8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,506,217,1	4,696,465,6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,394,0	4,631,9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,394,0	4,631,9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,495,823,1	4,691,833,8
51	Засгийн газрын хувь оролцоо	4,495,823,1	4,691,833,8
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,873,754,6	1,873,754,7
51200	Хуримтлагдсан үр дүн	1,472,434,6	1,668,445,3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,149,633,7	1,149,633,8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,506,217,1	4,696,465,6

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,815,494,1	2,232,849,0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	57,159,8	35,851,6
110	Орлогын албан татвар	35,681,0	25,201,8
1100	Хувь хүний орлогын албан татвар	35,681,0	25,201,8
113	Хөрөнгийн албан татвар	600,0	1,396,0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	20,878,7	9,253,8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,662,3	1,177,5
1181	Газрын төлбөр	19,216,4	8,076,2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	579,025,7	400,379,3
120	Нийтлэг татварын бус орлого	579,025,7	400,379,3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,179,308,5	1,796,618,1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,400,561,5	1,952,991,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,400,561,5	1,952,991,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,690,986,1	1,882,772,3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,043,461,7	1,178,411,6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	134,183,9	154,405,5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,787,7	66,323,5
2104	Хангамж, бараа материалын зардал	91,224,6	60,231,0
2105	Нормативт зардал	61,836,0	91,530,2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	817,7	11,900,4
2107	Томилолт, зочны зардал	4,772,0	3,570,0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,407,7	4,788,2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	272,494,3	311,611,0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	709,575,4	70,218,6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	414,932,5	279,858,1
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	370,0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	59,051,3	84,217,5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	355,881,1	196,010,6

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,873,754,6	1,149,633,7	1,116,592,6	4,139,981,1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-39,112.91	-39,112.91
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,873,754,6	1,149,633,7	1,116,553,5	4,139,942,0
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	355,881,1	355,881,1
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,873,754,6	1,149,633,7	1,472,434,6	4,495,823,2
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,873,754,6	1,149,633,7	1,472,434,6	4,495,823,2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,873,754,6	1,149,633,7	1,472,434,6	4,495,823,2
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	196,010,6	196,010,6
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,873,754,6	1,149,633,7	1,668,445,3	4,691,833,8

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,322,962,4	2,037,209,5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	57,159,8	35,851,6
110	Орлогын албан татвар	35,681,0	25,201,8
1100	Хувь хүний орлогын албан татвар	35,681,0	25,201,8
113	Хөрөнгийн албан татвар	600,0	1,396,0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	20,878,7	9,253,8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,662,3	1,177,6
1181	Газрын төлбөр	19,216,4	8,076,2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	86,494,0	246,185,5
120	Нийтлэг татварын бус орлого	86,494,0	246,185,5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,179,308,5	1,755,172,4
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	931,093,8	929,405,1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51,842,0	225,772,2
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,182,778,2	586,462,3
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	13,594,4	13,532,7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,146,236,6	1,677,252,3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,146,236,6	1,677,252,3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,436,297,5	1,607,330,4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,043,461,7	1,178,179,7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	134,183,9	154,405,5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,787,7	66,383,5
2104	Хангамж, бараа материалын зардал	60,499,7	60,561,9
2105	Нормативт зардал	71,302,1	98,411,9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,024,3	11,011,8
2107	Томилолт, зочны зардал	4,772,0	3,570,0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,407,7	5,159,2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,858,0	29,646,9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	709,939,1	69,921,9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	176,725,7	359,957,2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	78,444,5	114,388,7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	78,444,5	114,388,7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-78,444,5	-114,388,7
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-43,000,0	0,0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	43,000,0	0,0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	55,281,1	245,568,5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	131,251,6	186,532,8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	186,532,8	432,101,4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,821,417,7	1,538,340,2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,551,966,5	1,451,680,2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,541,576,7	1,441,687,5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,131,940,1	1,091,278,4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,912,7	142,316,6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,853,2	63,207,5
2104	Хангамж, бараа материалын зардал	59,118,8	58,831,4
2105	Нормативт зардал	57,235,5	48,305,2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,314,1	14,295,6
2107	Томилот, зочны зардал	5,707,1	3,220,0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,176,6	5,120,9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,318,6	15,111,8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,389,8	9,992,7
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,389,8	9,992,7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	171,451,2	86,660,0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	98,000,0	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,821,417,7	1,639,533,5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	929,405,1	917,745,4
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	666,322,3	632,729,3
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,733,7	13,532,8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	196,956,6	75,526,0
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	10,000,	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0.00	75,325,2
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0.00	176,518,4

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	225,772,3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	225,772,3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	177,502,8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	82,156,5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,748,3
2104	Хангамж, бараа материалын зардал	401,2
2105	Нормативт зардал	50,106,6
2107	Томилот, зочны зардал	350,0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,740,2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,269,5
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,269,5
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	225,772,3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	225,772,3

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 1/96 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь харьяалах нутаг дэвсгэрийнх нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төрийн эрх бүхий байгууллагаас батлах төсөл, хөтөлбөрт санал өгөх, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгжгүй бөгөөд хяналтыг аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт аудитын алба, Санхүү, төрийн сангийн хэлтэс хэрэгжүүлэн ажилладаг байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт аудитын алба нь 2021 онд Орон нутгийн хөрөнгө оруулалт болон ОНХС, СХС-гийн 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төлөвлөгөөний нийт зардлын 1,953.0 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 19.3 сая төгрөгөөр гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 13.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 432.1 сая төгрөг болж өмнөх оноос 245.6 сая төгрөгөөр өссөн байна.

Авлага дансны үлдэгдэл 189.6 сая төгрөг болж 32.3 сая төгрөгөөр буурсан нь СХС-гийн зээл төлөлт хийгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 271.5 сая төгрөг болж 29.1 сая төгрөгөөр өссөн байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,803.1 сая төгрөг болж 52.2 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөрөнгө оруулалт бусад хөрөнгө шилжүүлсэнтэй холбоотой.

Биет бус хөрөнгийн дансны үлдэгдэл 66.7 сая төгрөг болж 2.2 сая төгрөгөөр буурсан нь хөрөнгө акталсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 4.6 сая төгрөг нь ХХОАТ-ын өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,691.8 сая төгрөг болж 3,742.6 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгө нэмэгдсэн, холбоотой байна.

Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 582.7 сая төгрөгөөр буюу 20.7 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 1,952.9 сая төгрөгөөр буюу 21.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа үйлчилгээний бусад болон үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,821.4 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1,821.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,821.4 сая төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 666.3 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 929.4 сая төгрөг, нийгмийн даатгалын сангийн төсвөөс 18.7 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 197.0 сая төгрөг, хандив тусламжийн орлогоос 10.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 632.7 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 917.7 сая төгрөг, нийгмийн даатгалын сангийн төсвөөс 13.5 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 75.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр орлого бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,538.3 сая төгрөг буюу 84.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд зааснаар 2021 онд 79.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 193.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 209.9 хувиар биелүүлсэн байна. Сумын төсвийн орлого 114.0 сая төгрөгөөр давсан нь хүү торгуулийн орлого, бусад орлого давж биелсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 225.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 92.8 сая, хангамж, бараа материалын зардалд 0.4 сая, норматив зардалд 50.1 сая, дотоод албан томилолт 0.4 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 33.8 сая, бусад зардалд 48.2 сая, нийт 225.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Засаг даргын Тамгын газар нь Бараа материалын дансанд бүртгэлтэй малын тооллого хийсэн бүртгэл, тайлан байхгүй, зөвхөн А дансыг үндэслэн бүртгэл тайланд тусгасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 154 мэдээллээс 2 мэдээлэл хугацаа хоцроон, 29 мэдээллийг байршуулаагүйд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 107.1 сая төгрөгийн 3 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал гараагүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 58.9 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулах бичилт хийгдээгүй болно.

4.2. Албан шаардлага

1.Санхүүгийн тайланд тусгагдсан авлагын 22.9 хувь нь СХС-гаас олгосон зээл, зээлийн хүүгийн 43.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлага байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих, журам”-ын 4.7 -д “Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө”, 5.2-т “Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгана” гэсэн заалттай нийцэхгүй байна. Мөн өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй тул хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

2.Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 3.5 сая төгрөгийн ажил, ОНХС-гийн хөрөнгөөр 82.9 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын бус арга хэмжээний “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын дэмжлэг”-ийн 3.5 сая төгрөгийн, ОНХС-гийн “мал угааврын ванн шинээр барих” 4.0 сая төгрөгийн, “Наадмын талбайг тохижуулах засварлах” 2.9 сая төгрөгийн, “Гал түймрээс сэргийлэх

зурвас татах” 5.0 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ огт хийгдээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Булган сумын ТТЗ	2	58.9	-	-	-	-	2	58.9	-	-